

***Банк ба Банк бус санхүүгийн байгууллагын
үндсэн үзүүлэлтүүдийн талаар хийсэн судалгаа***

ОРШИЛ

Аливаа улсын эдийн засгийн хөгжлийн нэгэн тулгуур хүчин зүйл бол санхүүгийн зуучлал юм. Санхүүгийн зуучлагч байгууллагуудын оролцоотойгоор хөрөнгийн илүүдэлтэй байгаа салбараас хомдолтой байгаа салбар руу хөрөнгө шилжиж, ингэснээр эдийн засагт шаардлагатай байгаа хөрөнгө оруулалтыг хийх боломжийг бүрдүүлдэг юм. Монгол улсад хоёр шатлалт банкны тогтолцоо үссэн 1991 оноос арилжааны банк болон бусад санхүүгийн байгууллагууд байгуулагдаж, ингэснээр санхүүгийн зуучлал хөгжиж эхэлсэн билээ. Хөгжлийн эхэн үед энэ салбар дахь үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин сул, менежмент тааруу, эдийн засаг таагүй байсан зэргээс үүдсэн банкны салбарын хямрал шийдвэрлэгдэж, сүүлийн жилүүдэд банк санхүүгийн секторын байдал тогтворжиж, хүмүүсийн банкинд итгэх итгэл нэмэгдсэнээр санхүүгийн зуучлал улам бүр гүнзгийрч байна.

Энэхүү судалгааны ажлын гол зорилго нь санхүүгийн зуучлалын гол байгууллагууд болох банк, ялангуяа хөгжөөд удаагүй байгаа банк бус санхүүгийн байгууллагын (ББСБ) сүүлийн 2 жилийн үндсэн үзүүлэлт болох зээл, өөрийн хөрөнгө, орлого, зарлага, ашиг/алдагдал зэргийг харьцуулан дүгнэлт хийхэд оршино. Энэхүү судалгаанд 2001 оны 1 дүгээр улирлын¹, мөн оны 4 дүгээр улирлын болон 2002 оны 4 дүгээр улирлын банкны болон ББСБ-ын үзүүлэлтүүдийг авч ашигласан болно.

БАНК

Одоогийн байдлаар Монгол улсад 16 банк үйл ажиллагаагаа явуулж байгаагийн 1 (Хадгаламж банк) нь төрийн, 2 (УБ Хотын банк, Шинэчлэл банк) нь төрийн өмчийн бага хэмжээний оролцоотой, бусад нь хувийн банк байна. 2002 оны 6 дугаар сард

¹ Энд Чингисхаан ББСБ үйл ажиллагаагаа эхэлсэнээр ББСБ-ын системд гарсан өөрчлөлтүүдийг тодорхой гаргахын тулд 2001 оны 1 дүгээр улирлын үзүүлэлтүүдийг оруулан тооцв.

хамгийн том банк болох ХХ банкыг, 2003 оны 1 дүгээр сард хөдөө орон нутагт хамгийн их салбартай ХАА-н банкыг тус тус хувьчиллаа.

1999 оны банкны хямралаас хойш банкны салбарын үзүүлэлтүүд харьцангуй тогтворжиж, сайжрах төлөвдөө орсон ба санхүүгийн чадварын хувьд сул, өндөр эрсдэлтэй хэмээн тооцогддог байсан ХАА-н банкинд 2000 оноос менежментийн шинэчлэлийг хийснээр уг банкны үзүүлэлтүүд сайжирч, хөдөө орон нутаг дахь зээлжүүлэлтийг сайжруулж, санхүүгийн үйлчилгээ, зуучлалыг гүнзгийрүүлэх эхлэлийг тавьсан. Эдгээр 16 банкны 13 нь хөдөөд нийт 470 салбар нэгжтэй ба 4-ийх нь салбар нэгжийн тоо 10-аас дээш байна.

Банкны үндсэн үзүүлэлтүүдийг нэгтгэсэн байдлаар харуулбал:

Хүснэгт 1.

(тэрбум төг.)

	2001 оны 1 улиралд	2001 оны эцэст	Өсөлт (%)	2002 оны эцэст	Өсөлт (%)
Нийт актив	243.931	332.731	36.4	492.984	48.2
Нийт зээл	80.440	135.071	67.9	231.450	71.3
Чанаргүй зээл	15.694	10.866	-30.8	16.564	52.4
Өөрийн хөрөнгө	27.679	47.173	70.4	61.289	29.9
Орлого	9.554	52.140	445.7	84.565	62.2
Зарлага	6.608	42.285	539.9	73.574	74.0
Ашиг/алдагдал	2.946	9.855	234.5	10.991	11.5

2001 оны эхний улирлаас оны эцэс хүртэл орлого 4.5 дахин (42.586 төг.), зарлага 5.4 (35.677 төг.) дахин өсч, цэвэр ашиг 2.3 дахин (6.909 төг.) өсч 9.855 тэрбум төгрөгт хүрчээ. Үүнийг нарийвчлан авч үзвэл энэ хугацаанд банкны орлогын ихэнх хувийг бүрдүүлдэг хүүгийн орлого 6.593 тэрбум төгрөгөөс 34.971 тэрбумд хүрсэн буюу 5.24 дахин, хүүгийн зардал 2.748 тэрбумаас 13.42 тэрбумд буюу 4.88 дахин өсчээ. Өөрөөр хэлбэл энэ хугацаанд банкуудын эх үүсвэрийн татан төвлөрүүлэлт сайжирч, зээл олголт ихсэж, ингэснээр санхүүгийн зуучлал улам бүр гүнзгийрсэн гэсэн үг юм.

2001 оны эцэст банкны салбарын нийт зээлийн хэмжээ 135.1 тэрбум байсан нь нийт активийн 40.6 хувь, ДНБ-ын 12.1 хувьтай тэнцүү, 2002 оны нийт зээлийн хэмжээ 231.45 тэрбум төгрөг буюу нийт активийн 46.9 хувь, ДНБ-ын 18.8 хувьтай тэнцүү байлаа.

Чанаргүй зээлийн бодит тоон хэмжээ эхний үед 30.8 хувиар буурч, 2002 онд 52.4 хувь өссөн үзүүлэлттэй гарсан боловч нийт зээлийн багцад эзлэх хувийг авч үзвэл энэ нь 2001 оны эхний улиралд 19.5 хувь байж оны эцсийн байдлаар 8 хувь болж буурсан ба харин 2002 онд 7.1 хувь болж 0.9 нэгжээр буурчээ.

Банкны ашигт ажиллагааг хэмжих хэмжигдэхүүн нь татварын дараах ашгийг нийт активийн хэмжээнд харьцуулж тооцдог нийт активийн өгөөж (ROA) юм. Өөрөөр хэлбэл, нийт активийн өгөөж нь банк активаа хир ашигтай байршуулж байгааг тодорхойлдог үзүүлэлт ба өрөнхийдөө энэ нь 1 хувиас дээш байхад банкны үйл ажиллагааг давгүй гэж шинжээчид үнэлдэг. 2001 оны эхний улирлын байдлаар энэхүү харьцаа нь 1.21 хувь, мөн оны эцэст 2.96 хувь, харин 2002 оны эцсийн байдлаар 2.23 хувь байв.

Өөр нэгэн хэмжигдэхүүн нь өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) ба үүнийг тооцоходоо татварын дараахь орлогоо өөрийн хөрөнгөдөө харьцуулдаг. Энэхүү үзүүлэлт нь нь уг банкны хувьцаа эзэмшигчид өөрийн оруулсан хөрөнгө оруулалтдаа ямархуу ашиг олж байгааг илэрхийлдэг бөгөөд банкны системийн хувьд уг үзүүлэлт нь 2001 оны эхний улирлын байдлаар 10.6 хувь, 2001 оны эцэст 20.9 хувь, харин 2002 оны эцэст 17.93 хувьтай байлаа. ROA болон ROE үзүүлэлтийг одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулж буй банк тус бүрээр доорхи хүснэгтэд харуулав.

Хүснэгт 2. Банкуудын ROA ба ROE (хувиар)

Банкууд	2001 оны 1 улирал		2001 оны эцэст		2002 оны эцэст	
	ROA	ROE	ROA	ROE	ROA	ROE
Анод	0.59	5.88	1.46	16.94	0.41	4.45
Голомт	0.41	5.26	1.08	17.14	1.07	14.95
Зоос	2.84	11.56	4.6	20.79	2.05	15.17
Интер	-	-	1.04	2.86	0.09	0.53
Капитрон	-	-	0.11	0.13	1.79	8.61
Кредит	0.73	1.2	5.92	7.92	3.86	8.81
Менатеп	-	-	-	-	-0.58	-1.12
Монгол Шуудан	0.33	1.66	2.3	13.89	2.07	18.8
Тээвэр Хөгжил	0.44	1.05	4.93	9.3	2	6.54
Улаанбаатар хот	-0.05	-0.24	2.12	9.31	4.13	19.36
Хадгаламж	0.13	3.11	1.34	22.22	1.42	20.73
Хас	-	-	0	0	-0.46	-1.79
Хөдөө аж ахуй	0.55	-41.12	3.71	55.53	4.07	55.95
Худалдаа Хөгжил	2.24	19.76	4.95	42.48	3.67	38.61
Шинэчлэл	0.29	0.65	-5.96	-19.53	0.96	3.23
Эрэл	0.59	0.84	2.81	4.58	2.11	3.28
Нэгдсэн	1.21	10.64	2.96	20.89	2.23	17.93

Эндээс харахад, 2001 оны эхний улирлын байдлаар ердөө 2 буюу Зоос ба Худалдаа Хөгжлийн банкуудын ROA үзүүлэлт 1 хувиас дээш байсан бол 2001 оны эцэст Капитрон, Хас, Шинэчлэл банкуудаас бусад нь, 2002 оны эцэст Анод, Интер, Менатеп, Хас, Шинэчлэл банкуудаас бусад нь зохимжтой гэж үзсэн түвшинд байна. Хэдийгээр Анод ба Интер банкны нийт актив 2002 онд 34 ба 126 хувиар тус тус өссөн ч цэвэр ашиг нь 2.66 ба 4.53 дахин буурсан нь анхаарал татаж байна. Харин өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлтийн хувьд 2001 оны эхний улиралд Худалдаа Хөгжлийн банк (19.76 хувь), 2001 оны эцэст Хөдөө Аж Ахуйн банк (55.53 хувь), 2002 оны эцэст мөн л Хөдөө Аж Ахуйн банк (55.95 хувь) хамгийн өндөр өгөөжийн үзүүлэлттэй байлаа.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

ББСБ нь 1999 оноос эхлэн шинээр үүсч хөгжиж эхэлсэн ба 1999 онд 7, 2000 онд 23, 2001 онд 28 байсан бол 2002 оны эцсийн байдлаар 66 болж өргөжин тэлсээр байна. Эдгээр 66 банк бус санхүүгийн байгууллагын ердөө 3 нь Завхан, Архангай, Төв аймгуудад, 3 нь Дархан-Уул аймагт, бусад 60 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулдаг ба Кредит Монгол ББСБ нь Улаанбаатар хотоос гадна Баянхонгор, Өвөрхангай, Архангай аймгуудад салбар нэгжтэй.

Хэдийгээр "ББСБ-ын үйл ажиллагааны тухай хууль"-д зааснаар зээл, факторинг, санхүүгийн түрээс зэрэг 10 банк бус санхүүгийн үйл ажиллагаа байна хэмээн тодорхойлсон ч зээлээс бусад үйл ажиллагаа нь харьцангуй түгээмэл бус, эрхлэх туршлага бага зэргээс шалтгаалан зөвшөөрөл авсан ББСБ-ын дийлэнхи олонхи нь зөвхөн зээлийн үйлчилгээ үзүүлдэг ба энэ нь жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, макро эдийн засгийн гол үзүүлэлт болох ядуурал, ажилгүйдлийг бууруулахад чухал үүрэгтэй юм. 2002 оны эцсийн байдлаар 63 нь зээлийн үйл ажиллагаа явуулдагаас 10 нь валютын үйл ажиллагаа, 1 нь мөнгөн гүйвуулагын үйл ажиллагаа, 1 нь батлан даалтын үйл ажиллагаа давхар эрхэлдэг бөгөөд, харин үлдсэн 3 ББСБ нь түрээс, факторинг, төлбөр тооцооны үйл ажиллагаа явуулдаг байна.

2001 оны эхний улирлын байдлаар ББСБ-с олгосон зээлийн хэмжээ 1.82 тэрбум төгрөг, мөн оны эцсийн байдлаар 13.2 тэрбум төгрөг байсан бол 2002 оны эцэст энэ нь 2.72 дахин өсөж 36.0 тэрбум төгрөгт хүрчээ. 2001 оны 1 дүгээр улиралд ББСБ-уудын нийт активийн хэмжээ 5.2 тэрбум ба үүнд эзлэх зээлийн хувь 35, харин уг оны

Эцэст нийт актив нь 23.4 тэрбум төгрөг, үүний 56.4 хувь нь нийт зээл байсан бол энэхүү үзүүлэлт нь 2002 онд 88.5 хувиар өсч 44.1 тэрбумд хүрсэн ба харин үүнд эзлэх зээлийн хэмжээ 81.6 хувь болсон байна. Уг хугацаанд чанаргүй зээлийн хэмжээ 0.03 тэрбум төгрөгөөс 0.4 тэрбумд хүрсэн ба нийт зээлийн багцад эзлэх хувь нь 2001 оны 1 улирлын сүүлчээс оны эцэс хүртэл 1.7 хувиас 0.28 хувь болж буурсан боловч уг үзүүлэлт нь 2002 оны эцэс гэхэд эргээд 1.2 хувь болж өсчээ. Эхний үеийн бууралт нь 2001 онд олгосон зээлийн хэмжээ огцом өссөнтэй, харин дараагийн үеийн өсөлт нь ББСБ-үуд байгуулагдсан эхний үедээ олгосон зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь болсонтой, үүнтэй уялдан гарч байгаа асуудлуудаас үүдсэн байж болох талтай. ББСБес олгосон нийт зээлийн хэмжээг ДНБ-д харьцуулан авч үзвэл энэ нь 2001 оны эцсийн байдлаар 1.2 хувь, харин 2002 оны эцэст 2.9 хувьтай байв.

Системийн өөрийн хөрөнгийн нийт хэмжээ 2001 оны эхний улирлын байдлаар 1.9 тэрбум, оны эцэст 20.3 тэрбум төгрөг, 2002 онд 25.7 тэрбум төгрөг болж 2002 онд 26.6 хувиар өссөн бөгөөд энэ нь нийт пассив ба өөрийн хөрөнгийн 36.5 хувь (2001 оны эхэнд), 86.6 хувь (2001 оны эцэст), 58.4 хувь (2002 он) байв. 2001 оны эхний улирлаас оны эцэст 0.06 тэрбум төгрөгийн алдагдалаас 0.1 төгрөгийн ашигтай болж өссөн ба 2002 оны эцсийн байдлаар ашиг нь 12 дахин өсч, 1.2 тэрбум болсон байна. Мөн хугацаанд орлого 0.55 тэрбум төгрөгөөс 4.4 тэрбум, зарлага 0.61 тэрбуунаас 3.2 тэрбум болж тус тус өсчээ. Үүнийг хүснэгтээр нэгтгэн харуулбал:

Хүснэгт 3. (тэрбум төг.)

	2001 оны I улиралд	2001 оны эцэст	<i>Өсөлт (%)</i>	2002 оны эцэст	<i>Өсөлт (%)</i>
Нийт актив	5.194	23.392	350.4	44.084	88.5
Нийт зээл	1.824	13.198	623.6	36.040	173.1
Чанаргүй зээл	0.033	0.038	15.2	0.420	1005.3
Өөрийн хөрөнгө	1.866	20.250	985.2	25.743	27.1
Орлого	0.551	1.221	121.6	4.439	263.6
Зарлага	0.610	1.105	81.1	3.227	192.0
Ашиг/алдагдал	-0.059	0.116	296.6	1.212	944.8

Одоогоор үйл ажиллагаагаа явуулж буй ББСБ-уудаас хамгийн том нь болох Чингисхаан ББСБ нь 2001 оны 4 дүгээр улиралд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба энэ нь ББСБ-ын систем дэх өсөлтийн гол хүчин зүйл болсон юм. Дор хүснэгтэд ББСБ-ын системийн болон Чингисхаан ББСБ-ын үндсэн үзүүлэлтийг харьцуулан харууллаа.

Хүснэгт 4.

(тэрбум төг.)

	2001 оны эцэст			2002 оны эцэст		
	Нэгдсэн	Чингисхаан	Хувь (%)	Нэгдсэн	Чингисхаан	Хувь (%)
Нийт актив	23.392	14.952	63.92	44.084	31.625	71.74
Нийт зээл	13.198	10.094	76.48	36.04	29.7	82.41
Чанаргүй зээл	0.038	-	-	0.42	-	-
Өөрийн хөрөнгө	20.25	14.107	69.66	25.743	17.173	66.71
Орлого	1.221	0.29	23.71	4.439	2.284	51.45
Зарлага	1.105	0.288	26.1	3.227	1.687	52.28
Ашиг/алдагдал	0.116	0.001	1.02	1.212	0.597	49.25

Эндээс харахад Чингисхаан ББСБ-ын нийт системийн үндсэн үзүүлэлтэд эзлэх хувь өндөр тус салбарын илүү бодит өсөлтийг авч үзэхийн тулд Чингисхаан ББСБ-ын үзүүлэлтүүдийг оролцуулалгүй тооцож доор хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 5.

(тэрбум төг.)

	2001 оны I улиралд	2001 оны эцэст	Өсөлт (%)	2002 оны эцэст	Өсөлт (%)
Нийт актив	5.194	8.440	62.50	12.459	47.62
Нийт зээл	1.824	3.104	70.18	6.340	104.25
Чанаргүй зээл	0.033	0.038	15.15	0.420	1005.26
Өөрийн хөрөнгө	1.866	6.143	229.21	8.570	39.51
Орлого	0.551	0.932	69.15	2.155	131.22
Зарлага	0.61	0.817	33.93	1.540	88.49
Ашиг/алдагдал	-0.059	0.115	294.90	0.615	434.78

Дээрхи хүснэгтээс харахад чанаргүй зээлийн хэмжээ 2001 оноос 2002 онд 10 дахин өсч, 0.4 тэрбум төгрөгт хүрсэн нь анхаарал татаж байна. 2001 оны байдлаар чанаргүй зээлийн 50.8 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 49.2 хувь нь хэвийн бус зээл байсан бол 2002 онд үүний 28.5 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 24.3 нь хэвийн бус зээл, 40.5 хувь нь эргэлзээтэй зээл, 6.7 хувь нь муу зээл байна. Энэ нь дээр дурдсанчлан байгуулагдсан эхний үеүүдэд олгосон зээлийн эргэн төлөлтийн хугацаа болж байгаагаас үүдсэн байж болох бөгөөд иймд эрсдэлээ тооцон, зээлийн зөв бодлого явуулахад анхаарах хэрэгтэй болов уу.

ББСБ-уудын ашиг тогтвортой өсөх хандлагатай болж, санхүүгийн зуучлалд гүйцэтгэх үүрэг нь гүнзгийрсээр байгаа, хөдөө хотын хөгжлийн заагийг арилгах бодлогын хүрээнд шинээр байгуулагдаж байгаа ББСБ-ын дүрмийн санг байршилаас шалтгаалан ялгаатай тогтоосон хэдий ч хөдөөд үйл ажиллагаагаа явуулж байгаа ББСБ-ын тоо хэтэрхий чамлалттай байна. 2002 оны 2 дугаар сард хот хөдөөгийн

зээлдэгчдийн дунд явуулсан санал асуулгын² дүнгээс харахад судалгаанд оролцогчдын ердөө 6.6 хувь нь зээлийн эх үүсвэрээ ББСБ-с авдаг гэсэн ба энэ нь танил тал, найз нөхөд, хувь хүнээс зээл авдаг гэж хариулсан 10.2 хувиас бага байгаа нь ББСБ цаашид өргөжин тэлж, санхүүгийн зуучлалаа улам бүр гүнзгийрүүлэх боломжтойг илтгэж байна.

ББСБ-ын ашигт ажиллагааг тодорхойлох ROA (return on asset) ба ROE (return on equity) хэмжигдэхүүнийг 2002 оны эцсийн байдлаар авч үзье. Хамгийн өндөр нийт активийн өгөөжийн үзүүлэлттэй байгаа нь Төв аймагт үйл ажиллагаагаа явуулдаг Төв Хөгжил ББСБ (25 хувь), харин хамгийн өндөр өөрийн хөрөнгийн өгөөжтэй нь Транс Капитал ББСБ (33 хувь) байна. ББСБ-ын системийн хамгийн том нь болох Чингисхаан ББСБ-ын ROA нь 2 хувь ба ROE нь 3 хувь байна³.

ББСБ-ын өсөлтийг банкуудын адилтгах үзүүлэлтэд харьцуулсан байдлаар харуулбал:

Хүснэгт 6.

(хувиар)

	2001 оны 1 улиралд	2001 оны эцэст	Өсөлт (нэгж)	2002 оны эцэст	Өсөлт (нэгж)
Нийт актив	2.13	7.03	4.90	8.94	1.91
Нийт зээл	2.27	9.77	7.50	15.57	5.80
Цэвэр зээл	2.63	10.19	7.56	15.96	5.77
Чанартгүй зээл	0.21	0.35	0.14	2.54	2.19
Өөрийн хөрөнгө	6.74	42.93	36.19	42.00	-0.92
Орлого	5.77	2.34	-3.43	5.25	2.91
Зарлага	9.23	2.61	-6.62	4.39	1.77
Ашиг/алдагдал	-	1.18	-	11.03	9.85

ББСБ-с олгосон зээл нь 2001 оны эхний улирлын байдлаар банкуудын олгосон зээлийн 2.27 хувь байсан ба үүнээс хойш тогтмол өсөж 2001 оны эцэст 9.8 хувь, 2002 оны эцэст 15.6 хувь болжээ. Зээлжүүлэлтэд ББСБ-ын оруулах хувь нэмэр нэмэгдэхийн хирээр зээлийн бодлогоо оновчтой явуулж, эрсдэлээ зөв тооцох зайлшгүй шаардлагатай. Харин өөрийн хөрөнгийн огцом өсөлтийг мөн л Чингисхаан ББСБ-ын үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй холбон тайлбарлаж болно.

² Н. Амар, Г. Ариунхишиг. "Банкны зээлдэгчдийн дунд явуулсан санал асуулга, судалгааны ажлын дун"

³ ББСБ-ын өгөөжийн үзүүлэлтүүдийг Хавсралт 1-с харна уу.

2001 оны эцсийн байдлаар харуулсан орлого ба зарлагын харьцаа 2001 оны эхний улирлаас буурсан нь банкууд дахь хадгаламж ба олгосон зээлийн хэмжээ эрс ихэссэнтэй холбоотой.

Одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудаас хамгийн том болох гадаадын хөрөнгө оруулалттай Чингисхаан хаан ББСБ-ын зээлийн хэмжээг олгосон зээлийн хэмжээгээрээ бусад банкуудаасаа бага байгаа Кредит, Тээвэр хөгжил, ХАС, Шинэчлэл, Эрэл, УБ хотын банкуудын 2002 оны байдлаарх зээлийн өрийн үлдэгдлийн нийлбэр дүнгүүдтэй харьцуулж дор хүснэгтэд харуулбал:


Хүснэгт 7.

(тэрбум төг.)

	Чингисхаан ББСБ	Кредит+Тээвэрхөгжил+ ХАС+Шинэчлэл+Эрэл+УБ хот
2002 оны 1 улирал	12.863	17.321
2002 оны 2 улирал	13.475	21.563
2002 оны 3 улирал	25.314	24.758
2002 оны 4 улирал	29.7	25.558

Эндээс харахад хэдийгээр 2002 оны эхний улирлын байдлаар сонгосон банкуудын зээл 34.65 хувиар илүү байж, 2-р улиралд 6 банкны олгосон зээлийн хэмжээ харьцангуй хурдтай өссөн ч 3 ба 4 дүгээр улиралд Чингисхаан ББСБ-ын зээл олголт эрс хурдтай өсөж 2002 оны эцэст уг ББСБ-ын зээлийн хэмжээг 6 банкныхтай харьцуулхад 16.2 хувиар их болжээ.

График1.



Дээр дурьдсан 6 банкны үндсэн үзүүлэлтүүдийг Чингисхаан ББСБ-ыхтай харьцуулж хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 8.

(тэрбум төг.)

	Он	Сонгосон 6 банк	Чингисхаан ББСБ
Нийт актив	2001	21.647	14.952
	2002	35.710	31.625
Зээлийн өрийн үлдэгдэл	2001	17.276	10.094
	2002	25.558	29.700
Чанаргүй зээл	2001	1.020	-
	2002	0.591	-
Орлого	2001	0.587	0.290
	2002	7.147	2.284
Зарлага	2001	0.390	0.288
	2002	6.177	1.687
Ашиг	2001	0.197	0.002
	2002	0.969	0.597

График 2.





График3.



Дээрхи хүснэгт болон графикаас харахад Чингисхаан ББСБ-ын зээлийн өрийн үлдэгдэл 2002 онд огцом нэмэгдэж сонгосон 6 банкны нийт зээлийн өрийн үлдэгдэлээс 16.2 хувиар илүү болсон бол энэ хугацаанд эдгээр 6 банкны нийт актив 64.96 хувиар, Чингисхаан ББСБ-ын актив 110 хувиар өсч, ялгаа нь 64.1 хувиар буурчээ. Харин уг 6 банкны орлого ба зарлага 12.2 ба 15.8 дахин тус тус өссөн байна. Чингисхаан ББСБ-ын орлого 7.9 дахин, зарлага 5.8 дахин өсч, орлогын ялгаа нь 2001 оноос 2002 онд 16.4 дахин, зарлагын ялгаа 44 дахин нэмэгджээ. Банкуудын ашиг 2002 онд 4.9 дахин, Чингисхаан ББСБ-ых 298.5 дахин өсч, ялгаа нь 1.9 дахин өссөн байна.

ДҮГНЭЛТ

Дээрхи хэсгүүдээс харахад сүүлийн жилүүдэд банкууд болон ББСБ-ын үйл ажиллагаа сайжирч, санхүүгийн зуучлал гүнзгийрч байгаа нь харагдаж байна. Хэдийгээр ББСБ үйл ажиллагаа эрхлээд удаагүй, ердөө 3 жил гаруйхан болж байгаа ч жижиг, дунд бизнес эрхлэгчдийг зээлээр хангахад оруулах хувь нэмэр нь жилээс жилд нэмэгдсээр байна. Гэсэн хэдий ч орон нутагт үйл ажиллагааг явуулж буй ББСБ-уудын тоо хэт цөөн, ББСБ-ын болон уг байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээлэл хомс зэргээс иргэд, жижиг болон дунд бизнес эрхлэгчид зээлийн хэрэгцээгээ танил тал, найз нөхдөөсөө зээлэх замаар хангаж байгааг анхаарах хэрэгтэй байна. Мөн үйл ажиллагаа явуулах эрх авсан ББСБ-уудын ихэнхи нь зээл олгох үйлчилгээ үзүүлж байгаа ба тэдгээрийн олгосон зээлийн хэмжээ ихсэж санхүүгийн секторт эзлэх байр суурь өргөжихийн хэрээр тэдний эрсдэл тодорхой хэмжээгээр нэмэгдэж байгаа билээ. Иймд ББСБ-д тавих хяналт шалгалтаа зөвхөн

улирал тутам тайлан тэнцэл авсанаар хязгаарлалгүйгээр, зээлийн эрсдэлээ зөв тооцож, зээлийн зөв бодлого баримталж, үйл ажиллагаагаа хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр үнэн зөв цацаж байгаа эсэхэд анхаарч, энэ чиглэлд тавих хяналт шалгалтаа чангатгах хэрэгтэй байна.

Монгол банкаас ББСБ-ын дүрмийн санг тогтоохдоо хот суурин газарт 100 сая, хөдөөд 1 сая төгрөг гэж тогтоосон, шинээр 2002 оны 12 дугаар сард "Банк Бус Санхүүгийн Үйл Ажиллагааны Тухай" хууль батлагдсан, ББСБ-д банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, цуцлах, хяналт тавих журмийг шинэчлэн боловсруулсан зэрэг хүчин зүйлс нь ББС-ийн үйл ажиллагаа явуулах хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, дээр дурьдсан хүндрэлүүдийг арилгаж, санхүүгийн зуучлалд оруулах хувь нэмрийг улам бүр нэмэгдүүлэхэд түлхэц болно гэж дүгнэж байна.